

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын ТТЗ-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/019/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 88095436 Цахим хаяг:
Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг:
Ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 01/307

танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 187.8 сая төгрөг буюу 4.5 хувиар өссөн нь тайлант онд Засаг даргын Тамгын газар нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 263.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 4.6 сая төгрөгийн компьютер, бусад тоног төхөөрөмж, 0.7 сая төгрөгийн теннисний ширээ худалдан авсантай холбоотой өсөлт байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 169.9 сая төгрөгийн 4 зөрчил илэрч, 169.9 сая төгрөгийн 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Бүрэнтогтох сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны үр дүнгийн гэрээнд 7 зорилтын хүрээнд 150 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 79.3 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	/Мянган төгрөгөөр/	
			2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,038,723.53	1,476,106.72
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	675,911.48	855,406.24
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	178,826.94	256,347.89
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	183,985.11	364,352.59
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,834,927.5	1,757,780.64
6	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	119,561.91	12,950.2
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,715,365.59	1,744,830.44
8	Биет хөрөнгө		1,659,846.12	1,689,296.87
9	Биет бус хөрөнгө	13	55,519.47	55,533.57
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		2,873,651.03	3,233,887.35
11	НИЙТ ӨР ТӨЛБӨР		65,905.73	88,318.18
12	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		65,905.73	88,318.18
13	Өглөг		65,905.73	88,318.18
14	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,807,745.3	3,145,569.17
15	Засгийн газрын хувь оролцоо		2,807,745.3	3,145,569.17
16	Засгийн газрын оруулсан капитал		658,095.23	2,785.5
17	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		-	655,309.73
18	Хуримтлагдсан үр дүн		1,616,057.75	1,953,973.95
19	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		533,592.32	533,499.99
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		2,873,651.03	3,233,887.35

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	/Мянган төгрөгөөр/	
			2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,301,961.87	2,697,581.89
2	ТАТВАРЫН ОРЛОГО		869,632.65	893,370.94
3	Орлогын албан татвар		646,318.89	619,305.42
4	Хувь хүний орлогын албан татвар		646,318.89	619,305.42
5	Хөрөнгийн албан татвар		115,711.44	175,588.18
6	Бусад татвар, төлбөр, хураамж		107,602.32	98,477.34
7	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	366,930.54	1,804,210.95
8	Тусламжийн орлого		0	1,133,312.18
9	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,065,398.68	0
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,565,043.76	2,285,108.13
11	УРСГАЛ ЗАРДАЛ		2,565,043.76	2,285,108.13
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,506,362.56	2,179,241.01
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		802,015.7	870,164.8
14	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		102,553.9	98,872.94
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		659,739.81	687,941.79
16	Хангамж, бараа материалын зардал		475,637.31	54,571.48
17	Эд хогшил, урсгал засварын зардал		53,788.1	44,448.2
18	Томилолт, зочны зардал		2,900	2,138
19	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		117,598.2	28,879.33
20	Бараа үйлчилгээний бусад зардал		292,129.54	392,224.48
21	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		58,681.2	105,867.13
22	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		736,918.11	412,473.76

23	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,254	75,469.8
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-2,254	-75,469.8
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		734,664.11	337,003.96

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,016,683.56	2,737,279.69
2	ТАТВАРЫН ОРЛОГО	869,632.65	893,370.94
3	Орлогын албан татвар	646,318.89	619,305.42
4	Хөрөнгийн албан татвар	115,711.44	175,588.18
5	Бусад татвар, төлбөр, хураамж	107,602.32	98,477.34
6	Бусад нийтлэг төлбөр, хураамж	17,532.49	21,195.35
7	Газрын төлбөр	45,566.25	34,585.35
8	Байгалийн нөөц ашигласны төлбөр	44,503.59	42,696.65
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,497.23	1,843,908.75
10	Нийтлэг татварын бус орлого	53,497.23	58,850.82
11	Тусламжийн орлого	0	1,148,183.13
12	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	636,874.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,093,553.68	0
14	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,898,318.07	1,914,451.81
15	УРСГАЛ ЗАРДАЛ	1,898,318.07	1,914,451.81
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,847,219.17	1,808,584.68
17	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	794,721.87	880,605.19
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,407.34	98,710.5
19	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	660,929.81	667,535.58
20	Хангамж, бараа материалын зардал	80,740.46	43,251.58
21	Эд хогшил, урсгал засварын зардал	56,049.1	53,956.4
22	Томилолт, зочны зардал	2,900	2,138
23	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,933.3	42,607.23
24	Бараа үйлчилгээний бусад зардал	26,537.3	19,780.2
25	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,098.9	105,867.13
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,118,365.48	822,827.89
27	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	853,638.58	636,551.63
28	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	853,638.58	636,551.63
29	Дотоод эх үүсвэрээр	853,638.58	636,551.63
30	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-853,638.58	-636,551.63
31	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	112,335.8	6,781.5
32	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-112,335.8	-6,781.5
33	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	152,391.11	179,494.76
34	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	523,520.37	675,911.48
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	675,911.48	855,406.24

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,073,081.19	2,073,081.19
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,073,081.19	2,073,081.19
3	Тайлант үеийн үр дүн	734,664.11	734,664.11
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,807,745.3	2,807,745.3

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,807,745.3	2,807,745.3
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	92.33	92.33
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,807,837.63	2,807,837.63
8	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	727.58	727.58
9	Тайлант үеийн үр дүн	337,003.96	337,003.96
10	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,145,569.17	3,145,569.17

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,990,103.5	2,531,663.7	458,439.8	84.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,975,328.6	1,893,600.5	81,728.1	95.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,865,137.6	1,797,096.4	68,041.2	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	902,115.3	879,266.6	22,848.7	97.5
210101	Үндсэн цалин	530,610.1	517,546.4	13,063.7	97.5
210102	Нэмэгдэл	351,517.2	345,503.3	6,013.9	98.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,088.0	10,051.7	36.3	99.6
210104	Урамшуулал	9,900.0	6,165.2	3,734.8	62.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,710.5	98,710.5	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	62,625.8	62,625.8	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,021.2	9,021.2	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,510.6	4,510.6	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,510.6	4,510.6	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	18,042.3	18,042.3	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	671,841.5	667,535.6	4,305.9	99.4
210301	Гэрэл, цахилгаан	56,539.0	62,106.3	-5,567.3	109.8
210302	Түлш, халаалт	609,336.1	602,934.0	6,402.1	98.9
210303	Цэвэр, бохир ус	5,966.4	2,495.2	3,471.2	41.8
2104	Хангамж, бараа материалын зардал	47,286.7	37,531.2	9,755.5	79.4
210401	Бичиг хэрэг	16,456.6	14,807.0	1,649.6	90.0
210402	Тээвэр, шатахуун	18,955.9	14,304.7	4,651.2	75.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,903.5	3,803.5	100.0	97.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,557.0	-	1,557.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,413.7	4,616.0	1,797.7	72.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,989.0	58,316.3	8,672.7	87.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,910.0	7,019.5	1,890.5	78.8
210604	Урсгал засвар	58,079.0	51,296.8	6,782.2	88.3
2107	Томилолт, зочны зардал	4,000.0	2,138.0	1,862.0	53.5
210702	Дотоод албан томилолт	4,000.0	2,138.0	1,862.0	53.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,390.6	37,708.2	9,682.4	79.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,691.0	36,286.2	8,404.8	81.2
210803	Даатгалын үйлчилгээ	272.6	272.6	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600.0	411.1	188.9	68.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,227.0	427.0	800.0	34.8
210807	Газрын төлбөр	600.0	311.3	288.7	51.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,804.0	15,890.0	10,914.0	59.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,504.0	15,890.0	4,614.0	77.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,300.0	-	6,300.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,191.0	96,504.1	13,686.9	87.6

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	110,191.0	96,504.1	13,686.9	87.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	51,373.1	51,373.1	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,936.9	39,820.0	11,116.9	78.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,881.0	5,311.0	2,570.0	67.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	960,102.4	631,281.7	328,820.7	65.8
223001	Бусад хөрөнгө	960,102.4	631,281.7	328,820.7	65.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	54,672.5	6,781.5	47,891.0	12.4
230001	Эргэж төлөгдөх зээл	54,672.5	6,781.5	47,891.0	12.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,990,103.5	2,711,202.1	278,901.4	90.7
310,001.00	Улсын төсвөөс санхүүжих	2,990,103.5	2,711,202.1	278,901.4	90.7
310,004.00	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	660,500.0	636,800.0	23,700.0	96.4
32.00	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,329,600.0	2,074,402.1	255,197.9	89.0
320,001.00	Орон нутгийн төсвөөс	1,933,000.0	1,769,960.0	163,040.0	91.6
35.00	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	58,000.0	33,668.3	24,331.7	58.0
350,001.00	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,000.0	25,896.2	32,103.8	44.6
350,002.00	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,772.1	-7,772.1	-
350,003.00	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	338,600.0	270,773.8	67,826.2	80.0
4.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	675,911.5	-675,911.5	-
5.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	855,449.9	-855,449.9	-
61.00	БАЙГУУЛЛАГЫН ТОО	53.0	53.0	-	100.0
610,001.00	Төсвийн байгууллага	2.0	2.0	-	100.0
62.00	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.0	25.0	-	100.0
620,001.00	Удирдах ажилтан	2.0	2.0	-	100.0
620,002.00	Гүйцэтгэх ажилтан	20.0	20.0	-	100.0
620,003.00	Үйлчлэх ажилтан	3.0	3.0	-	100.0
65.00	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.0	26.0	-	100.0
650,001.00	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1.0	1.0	-	100.0
650,009.00	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.0	3.0	-	100.0
650,011.00	Улс төрийн албан хаагч (УТ)	1.0	1.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	46,266.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,266.5
122	Тусламжийн орлого	46,266.5

1221	Хандив тусламж /дотоод/	46,266.5
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,266.5
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,730.5
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,536.1
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,121.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,121.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,758.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,338.6
210104	Урамшуулал	1,338.6
2104	Хангамж, бараа материалын зардал	5,720.4
210401	Бичиг хэрэг	735.0
210402	Тээвэр, шатахуун	2,949.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,036.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	910.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	910.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,899.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,899.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,890.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,890.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,363.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,363.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,442.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,920.6
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	20,145.3
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-20,145.3
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-20,145.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,700.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан, 1 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудтай холбоотой зөрчил

Бүрэнтогтох сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 210.0 сая төгрөгийн алдаа илрүүлэн аудитын явцад бүрэн залруулж, нийт 54.1 сая төгрөгийн 6 зөрчил илэрч, 2.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 47.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй 3.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлагыг хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой зөрчил

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 169.9 сая төгрөгийн 4 зөрчил илэрч, 169.9 сая төгрөгийн 3 зөвлөмж, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Бүрэнтогтох сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

5.1 Албан шаардлага

Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:" гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн орлогоос 6 нэр төрлийн 53.1 сая төгрөгийн орлого тасарсан байна. Үүнд:

- Үйл ажиллагааны орлого 9.3 сая төгрөг,
- Шууд бус орлого 21.9 сая төгрөг,
- Түгээмэл тархацтай АМАТ 6.9 сая төгрөг,
- Хог хаягдлын үйлчилгээний төлбөр 1.5 сая төгрөг,
- Байгалийн ургамлын НАТөлбөр 1.6 сая төгрөг,
- Газрын дуудлага худалдаа 11.9 сая төгрөг тус тус тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх хэсэгт "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой:

Илрүүлэлт: Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Байгууллагын батлагдсан төсөв
- Худалдан авах ажиллагааны нэгтгэсэн төлөвлөгөө
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор" гэж заасныг тус тус зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь, иж бүрэн мэдээлж хэвших.

Илрүүлэлт: Бүрэнтогтох сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд 2018 оноос хойш үүссэн 116.8 сая төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байна. Энэ нь Төвсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь хэсэгт "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Соёлын төвийн халаалтын өрийг дахин судалж, төсөвт ачаалал үүсгэхгүйгээр богино хугацаанд жигд хуваарилан өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Харъяа байгууллагын алдааны нэгтгэл										
Авлага бүртгээгүй	1	3.2	1	3.2			1	3.2		
Өглөг бүртгээгүй	1	6.0	1	6.0			1	6.0		
ҮХ тод тайланд зөрүүтэй	1	174.7			1	174.7	1	174.7		
Төсвийн төлөвлөгөө зөрүүтэй	1	26.1			1	26.1	1	26.1		
Дүн	4	210.0	2	9.2	2	200.8	4	210.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн зөрчлийн нэгтгэл								
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	53.1					1	53.1
Соёлын төвийн тогтмол зардлын өглөг	1	116.8					1	116.8
Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй	1	-				1	-	
Дүн	3	169.9				1	-	2
Харъяа байгууллагын зөрчлийн нэгтгэл								
Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй	1	3.9				1	3.9	
Дотоод хяналт хангалтгүй	1	-						1
Өглөг барагдуулах арга хэмжээ аваагүй	1	47.6						1
Анхан шатны баримтыг хуурамчаар үйлдсэн	1	0.7	1	0.7				
Нийт дүн	4	52.3	1	0.7	1	3.9	1	47.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дасны тухай хуулийн хэрэгжилттэй хоолбоотой								
Хугацаа хоцроосон	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Харъяа байгууллагын зөрчлийн нэгтгэл -Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт								
Тэмцээн уралдаан	1	0.6	1	0.6				
Бэлэг дурсгал	1	1.2	1	1.2				
Дүн	2	1.8	2	1.8				